

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№22/561

ШУС, НУС

2021

**“АРИСТОТЕЛЬ”-ИЙН “УРАН ИЛТГЭХҮЙН УХААН”-Ы СЭТГҮҮЛ ЗҮЙ**

Б.Болд-Эрдэнэ\*

\*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, сэтгүүл зүйн доктор (Ph.D)

**Түлхүүр үгс:** Аристотель, уран илтгэхүйн ухаан, аман харилцаа, Монголын сэтгүүл зүй, нийгмийн харилцаа, мэдээллийн орон зай

**Н**ийгмийн харилцааны анхдагч хэлбэр нь аман яриа байсан нь гарцаагүй бөгөөд өдгөө хүртэл хүмүүс хоорондын хамгийн нөлөө бүхий мэдээллийн орчин болон оршсоор буй билээ. Хэдийгээр түүхийн эрин бүрд (бичиг үсэг, хэвлэх машин, телефон утас, телеграф, телевиз, радио, интернэт) мэдээллийн технологийн хөгжил дэвшил, өөрчлөлтийн түрэлт дор хүний, нийгмийн харилцаа цаашилбал үзэл санаа, үнэлэмж шинэчлэгдэн, амьдралын хэв маягт нэвчин урьд өмнө байгаагүй олон хэлбэр, суваг хэрэгслийн хэрэглээг бий болгон, төлөвшүүлж ирсэн боловч аман харилцааны үүрэг, нөлөө буураагүй болно. Өөрөөр хэлбэл хүний харилцааны төв, эхлэл нь үг яриа хэвээр гэсэн үг. Тиймээс нийгмийн харилцааны болон мэдээллийн орон зайн цөм бол үг яриа төвт тэмдэгтийн орчил гэж болно. Ийнхүү аман харилцааг хүний соёл иргэншлийг бүтээгч хэмээвээс

түүний дээд, төгс хэлбэр нь уран илтгэхүйн ухаан, чадвар болой.

Уран илтгэхүйн ухааны талаар эртнээс нааш гүн ухаантан, яруу найрагч, улс төр, цэргийн гарамгай зүтгэлтнүүд олныг өгүүлж, эргэцүүлэл бодлоо цэгцэлж ирсэн нь ч нийгмийн оюун санаа, сэтгэл зүйг эзэмдэхийн үндэс нь үг ярианы итгэн үнэмшүүлэх нөлөөнд байсанд оршино. Гэхдээ эртний Грекийн агуу сэтгэгч Аристотелийн “Уран илтгэхүйн ухаан”-ы түвшинд хүрэхүйц үзэл тайлбарын бүтээл үгүй билээ.

Аристотелийн онолоор уран илтгэхүй нь итгүүлэн үнэмшүүлэх үлгэр дуурайл, нөлөө бүхий илтгэгчийн мэдлэг бүрэн, зорилго тодорхой болоод сонсогчдын хүсэн хүлээж буй үг утгыг үнэнд нийцүүлэн илэрхийлэх ур чадвар ажээ. Энэхүү томъёоллыг шууд хуулбарлан, бодит үйл хэрэг болгож буй жишээг нийгмийн харилцааны (PR) мэдээллийн орон зайнаас элбэг, түгээмэл эшилж болно. Тэгээд ч энэ салбарын тэргүүлэх эрдэмтэн, судлаач Э.Бернейсийн “Бид дүр төрхийг бус харин бодит байдлыг бүтээдэг (Юнг, 2006)<sup>1</sup> хэмээн тодорхойлсон нь“ үнэнийг тодруулах зорилгот мэтгэл-

цэх “ур чадвар” гэж сургасан-тай цаг үе, харилцааны орчноос үүдэх ялгааг даван, мөн чанарыг тодотго-воос нэгэн утга эх үзэлд нэгджээ.

Гэхдээ өнөөгийн Монголын сэтгүүл зүй, улс төрийн мэтгэлцээн, нийгмийн харилцаанд “маргаанд зөвдөж үлдэх хуурамч ялалтад хүрэх (эристик), худал хуурмаг шалтаг үндэслэлийг зориуд санаа-тайгаар ашиглах аргаар ялах (софистика)” (Аристотель, 2009)<sup>2</sup> арга зонхилох илэрхийлэл болоод байгааг онцолмоор байна. Энэхүү хуурамч оюун дүгнэлтийг их сэтгэгч логикийн алдаа хэмээн шүүмжилсэн нь “итгүүлэн үнэмшүүлэх шаардлага бол юмны бодит зураг тодорхой бус үед гарч ирдэг тул . . . логикийн категориудаас өөр ойлголтыг хэрэглэх болдог”-т оршдог онцлог чанартай холбон үзжээ. Харин үнэнийг тодруулах зорилгоор марган мэтгэлцдэг диалектика нь чиглүүлэх асуулт тавих замаар ялалтад хүрдэг ур чадвар хэмээжээ. Харин софич хүн хуурамч нотолгоо гаргах гэж хөөцөлддөг, эрист нь ямар ч аргаар болов хамаагүй ялалт байгуулах гэж улайрдаг ажээ.

Дээрх томъёолол нь тайлба-раар үзвэл манай нийгмийн сүлжээ-ний орчин нь софист хэлбэрийн нотолгоог зорилгоо болгосон эрист сэтгэгдэл бичигчдийн илэрхий зо-хион байгуулалттай агуулга утгын түрэлтэд эрхшээгдсэн байгаа юм. Тиймээс ч нийгэм, цаг үеийн аливаа асуудал, үйл явдлын мөн чанар, бодит байдлыг бус харин өөрийн үзэл санааг зөвтгөх ямар нэгэн жишээ, худал, өнгөц мэдээллийг

нотолгоо мэтээр эшлэн, хэн нэгэн эсвэл ямар нэгэн байгууллага, субъектийг буруутгах зорилгод хөт-лөгдсөн харилцааны орчин ноёрхож байна. Сэтгүүл зүйн хувьд ч мөн адил хариулт нь агуулагдсан асуулт, зорилго нь илт ярилцлага, мөн чанарт үл холбогдох баримт, нэг талын үзэл тайлбар зэрэг мэдээл-лийн “бүтээгдэхүүн” зонхилж буй нь бодит байдал, учир шалтгааныг мэдэх боломжийг хязгаарлахад хүргэж байна.

**И**йм мэдээллийн давлагааны сонгодог жишээ нь Ковид-19 цар тахлын үеийн төрийн болоод мэдээллийн хэрэгслийн бий болгосон харилцааны орчин болно. Цар тахлын эхэн үеийн (2020 оны 2 сараас 11 сар хүртэл) мэдээллийн орон зай нь хижиг өвчний айдас, төрийг хэтийдгэн дээдлэх үзэл, эрх баригч засгийн газрын бүхнийг хязгаарлах санаархал зэргийг олон нийтийн санаа бодолд төлөвшүүлэн бататгахад чиглэж байв. Өдгөө эргэн санахад Монголд өвчлөлийн нэг ч бүртгэл үгүй үед бүхнийг хязгаарлах, халамжийг хавтгайруу-лан өргөжүүлэх, өвчний хурдтай тархацтай хөрш орны талаарх мэдээллийг олон удаа давтах, сэжиг-тэй тохиолдлыг хянан магадлалгүй олон нийтэд хүргэж байсан зэрэг нь эрист ноёрхсон харилцааны орчныг бүрдүүлж улмаар янз бүрийн худал, зөрчилт нотолгоонд автах нийгмийн сэтгэлзүйг бэлтгэсэн хэрэг байв.

Энэхүү нийгмийн сэтгэлзүйн хямрал, айдсыг бий болгоход төр болон эрүүл мэндийн салбарын албан тушаалтнуудын мэдэгдэл,

ярилцлага тодруулга, тайлбар зэрэг нь онцгой үүрэг, нөлөө үзүүлсэн. Түүнчлэн улс төрийн сонгууль, эрх баригч хүчний нэр хүндээ өсгөх сонирхол, олон нийтийн халамжийг шүтсэн сэтгэлгээ зэрэг субъектив хүчин зүйл ч логик бус үзэл хандлагад хөтөлсөн нь нууц биш билээ. Эртний Грекийн гүн сэтгэгч маань “уран илтгэхүйн ухаан бол задлан шинжлэх эрдэм ухаан болон зан суртахууныг хөндсөн улс төрийн ухаанаас тогтодог гэдгийг ... нэг хувьдаа диалектик лугаа, нөгөө хувьдаа софич бодол санаа лугаа төстэй” (Аристотель, 2009)<sup>3</sup> хэмээн тодотгоод санхүү, дайн ба энх, улс орноо хамгаалах, хүнсний бүтээгдэхүүн, хууль тогтоомж гэсэн таван асуудалд төвлөрөх ёстой гэжээ. Эдгээрээс улс орны аюулгүй байдалд төр байгууламж чухал гээд “... демократ байгууламж хэтэрхий суларснаар эсхүл чангалснаар эцэстээ олигархи байгууламжид шилждэг ... төр улсын ажил хэргийн тухай зөвлөлдөхөд түүхчдийн бүтээл ашигтай” (Аристотель, 2009)<sup>4</sup> гэж дэлгэрүүлэн тайлбарлажээ.

**Д**ээр өгүүлсэн улс төрийн таван асуудал нь өнөөгийн сэтгүүлзүйн хүрээнд ч голлох сэдэв асуудал хэвээр төдийгүй түүхийн баримт жишээг онцолсон нь орчин үеийн телевизийн инфотейнмэнт чиглэлийн мөн чанарыг тодотгосон байгаа юм. Инфотейнмэнт мэдээлэл, нэвтрүүлэг нь түүхэн дүр, үйл явдлаар дамжуулан цаг үеийн сорилт, асуудлыг үзэгчдэд нээн, улмаар эргэцүүлэл, нийгмийн тэр дундаа улс төрийн мэдээллийн

зорилго нь бодит, эрүүл оюун дүгнэлтэд чиглэсэн мэтгэлцээнд хүрэх гэсэн үг юм. Цаашилбал, төрийн байгууллагын мэдээлэл, харилцааны хүрээ нь улс орны амин чухал асуудлаар хязгаарлагдах нь хүчтэй засаглал, оюун санааны лидер байхуйн уг сурвалж ажээ. Энэхүү шалгуураар үзвэл манай улс төрийн мэдээлэл хэт задгай, үл ялих, өдөр тутмын урсгал сэдэв асуудалд хэт хутгалдаж, нэр хүнд, манлайлах нөлөө үгүй болсныг хялбар ойлгож болно.

Аристотелийн үзэл санааны бидэнд чухал өөр нэг санаа нь “ер нь болбоос эд баялгийн мөн чанар нь эзэмшихээсээ илүү ашиглахад оршдог, юу гэвэл эд баялаг гэдэг бол ... түүнээ ашиглах явдал” (Аристотель, 2009)<sup>5</sup> гэсэн тодорхойлолд байгаа юм. Үнэхээр ч Монголын эдийн засгийн сэтгүүл зүй уул уурхай, ашигт малтмалын сэдэв асуудалд төвлөрөхийн хирээр гадаадын хөрөнгө оруулалт, технологийн хүчин зүйл, дэлхийн зах зээлийн бодит байдал, дэгийг бус харин шууд ашиг, өмчлөлийн хийсвэр ойлголт, орлогын гэнэ томьёололд хошуурч байгаа нь хэт туйлширсан, эрүүл бус санаа бодлыг хөхиүлэн дэмжих буруу хандлагыг бий болгов. Бидний мэдээллийн орон зайд эзэмшигч хэмээх үзэл сэтгэлгээ хэт ноёрхож, хэрхэн ашиглах вэ, ашгаа юунд зарцуулах вэ, түүнийгээ ямар ирээдүйн хөрөнгө оруулалт болгох вэ зэрэг зөв голч мэтгэлцээн үгүйлэгдсэн байна.

Дээрх дүгнэлт нь уран илтгэхүйн ухаанд юуны тухай, ямар байр сууринаас хэрхэн өгүүлэх вэ гэдгийг тодотгож буй ч нөгөө талдаа мэдээлэл, үзэл бодлын илэрхийлэл нь голч, шударга, үнэн сайн санаа байж сая үр нөлөө үзүүлдгийг тодотгож буй хэрэг. Тиймээс ч түүний бүтээлд аз жаргал, сайн нэр, эд баялаг, бүсгүй хүний эрхэм чанар залуу нас гээд сэдэв асуудал бүрд буй гол түлхүүр санааг тайлбарлажээ.

Ер нь ямар ч нийтлэл, нэвтрүүлгийн гол хараа, “бай” нь хүний асуудал байдаг бөгөөд тэр нь эрт эдүгээ нэг л мөн чанартай бөлгөө. Ийнхүү хүндэтгэл бол ачтаны алдар нэрийн шинж, залуу насны гоо сайхан нь хурд, хүч шалгасан хүнд бэрхийг давах чадвар, өтөл насных бол уйтгар гуниггүй амьдрах зэргээр номлосон байна. Энэ нь хэдийгээр энгийн ярианы үр нөлөөний тухай мэт боловч мөн чанартаа бол хүнд итгүүлэн үнэмшүүлэх өгүүлэмжийн эгэл боловч эрхэм ухаан юм. Тэгээд ч сэтгүүл зүй, олон нийтийн харилцаа хүний харилцаанаас эхэлж, хүний харилцаагаар төгсдөг эргэх холбоонд нэгтгэгддэг. Яг ийм шалгуур шүүлтүүрээр дэнсэлбэл манай нийгмийн мэдээл-лийн орон зайд гаж, зүй бус үйлдлийг (өөрийгөө шатаах, хуурай өлсгөлөн зарлах, өвлийн хүйтэнд нүцгэн зогсох) агуу эр зоригийн илэрхийлэл болгох, хэт үгүйсгэлийг (засгийн газар огцрохыг тулган шаардах, вакцинжуулалтыг эсэргүү-цэх) нэр төр, эрх мэдлийн нандин чанар мэтээр үнэлэх, залуу хүн бүр халамжаар тэтгүүлж, бусдын дэмж-лэгээр сая зорилгодоо хүрэх

ёстой мэтийн нийтийн төөрөгдөл, төсөөлөл ноёрхож байна гэсэн үг.

Тэгэхлээр хүний сэтгэлийг олох гэдэг утга ярианыхаа агуулгыг зөв ончтой илэрхийлэхэд оршиж байна гэсэн үг. Их сэтгэгчийн үзэл тайлбар ч зөвлөх ярианы зорилго нь ашиг тус, ашиг тус бол сайн сайхан гээд түүнийгээ ангилжээ. Энэхүү ангиллаас өнөөгийн бидний мэдээлэл харилцаанд буй зарим нэгэн асуудалд холбоотой санааг тэмдэглэв.

**Ю**уны өмнө “хүмүүс хүсэлд нь нийцэн тохиолдож буй тэр зүйлийг чухалд үздэг, хүмүүс болбоос эсхүл өөртөө ямар ч муу муухайг агуулдаггүй зүйлийг эсхүл сайн сайхнаас хорт муу нь бага байгаа тэр зүйлийг хүсдэг” (Аристотель, 2009)<sup>6</sup> хэмээн тодотгосон нь PR-ийн түлхүүр мэдээллийг зорилгот хэрэглэгчдэд хүргэх тухай үзэл санааны үндэс ажээ. Нөгөө талаар хүн бүхний хэмжүүр, хүнд л байдаг гэгээлэг эрхэм зан чанарыг хүнлэг үзэл хэмээнэ гэсэн онч үгсийг хамтатган нэгтгэвэл нийгмийн харилцааны зорилго нь гэгээрэл, боловсрол болох нь ойлгомжтой.

Нөгөө талаар хүн гэдэг ухаант оршихуй боловч хэт хүсэл сонирхолдоо автах нь өөрийгөө өргөмжлөх, бүхний төвд байхыг эрмэлздэг гэмийн шалтгаан нь аминч үзэлтэй нь холбоотой хэрэг. Үүнийг ч мэдээллийн төөрөгдүүлэлт, худал, бодит бус үзэл санааг дэвэргэхэд ашигладаг бөгөөд түүхэн гажуудал, нийгмийн “инженерчлэл” зэрэг гунигт үйл явдал үзэгдлийг дагуулсан фашизм, коммунизм, терроризмын

үр үндсийг бий болгосныг бид мэднэ. Тиймээс хүсэл, эрмэлзэлд нийцүүлэн мэдээлэл, үзэл санааг түгээх нь зүйн хэрэг боловч хэт хөтлөгдөх нь буруу, зөрчилт үр дагаварт хүргэнэ. Иймээс их сэтгэгчийн “сайн сайхнаас хорт муу нь бага” гэсэн тодотгол нь мэдээллийн тэнцвэрт байдлын жорыг тодорхойлсон болохыг анхаарах хэрэгтэй. Мэдээлэл, харилцаа нь бодит байдал, цаг үе, амьдралаас үүдэлтэй бас нөлөөтэй орчин тул сайнтай, муутай, үнэнтэй худалтай эргэнэ. Төгс зөв, төгс сайн ч гэж үгүй. Тэгэхлээр

бидний сонголт илүү сайн гэдэгт төвлөрөх нь ойлгомжтой. Энэхүү санаагаа ч “ямар нэгэн шилдэг юмны их дээд хэмжээ илүү шилдэг байна, бас ямар нэгэн үлэмж сайхан юмны дээд хэмжээ илүү үлэмж сайхан байна, яагаад гэвэл илүү дээд, илүү үлэмж сайхан хүслийг төрүүлж

буй тэр зүйлс илүү шилдэг” (Аристотель, 2009)<sup>7</sup> хэмээн мөрдлөгөөр нотлон дэлгэрүүлжээ. Ийм мэдээллийн нөлөөний жишиг загвар, бодит жишээ нь “брэнд бүтээхүй” бөгөөд их сэтгэгч “хүчтэй татагдах хүсэл нь илүү дээд объект-тод хамаардаг” (Аристотель, 2009)<sup>8</sup> гэж маш оновчтой тайлбарлажээ. Ер нь **эхлэл болсон бүхэн, үнэ цэнтэй болсон**

**бүхэн, үнэн болсон бүхэн** илүү байна гэдгийг Аристотель тунхагласан нь санаандгүй зүйл биш бөгөөд сэтгүүл зүй (үнэн), PR (анх-дагч бай), нийгмийн сүлжээ (түрүүлж байрш) гээд нийгмийн бүх харилцаа, орчин хүчин төгөлдөр болсон маргашгүй мөрдлөг юм.

Аристотель зөвлөн илтгэгч ямар засаглалын үед байгаагаа сайтар мэдэж байж сая зорилгодоо хүрнэ гээд улс төрийн засаглалын хэлбэрийн зорилгыг “...демократын зорилго нь эрх чөлөө, олигархийнх эд баялаг, аристократынх хүмүүжил

ба хууль ёс, тиранийн хамгаалалт” гэжээ. Энэхүү засаглал ба зорилгын харьцааг үндэслэн Монголын мэдээллийн орон зайг үнэлбэл нийгмийн харилцаанд олигарх, төрийн мэдээлэлд тиран хэлбэрийнх хэвшиж буй ажээ. Өнөөгийн бидний цаг үед эрх чөлөөний үнэлэмж, манлай чанар, хүмүүжил, хууль ёсны эрхэмнэл мартагдсан. Тиймээс ёс суртахууны сургаал, хүмүүжлийн (би энд хуулиар тогтоосон боловсролыг хэлж байна, яагаад гэвэл хууль ёсны хязгаарлалтаас давж гардаггүй хүмүүс аристократ эрх мэдэл эдэлдэг) (Аристотель, 2009)<sup>9</sup> тухай яриаг үл хэрэгсэх болсон.



**Мэдээлэл харилцааны орон зай өөрийн оршин байгаа тогтолцоогоо хамгаалах зорилго дор бүрэлддэг гэсэн үг. Тиймээс манайд баян хоосны ялгаа, ядуурал, үнийн өсөлт, авлига, уул уурхай зэрэг эд баялгийн “шунал” тойрсон эрс үгүйсгэл, туйлшрал нийгмийн сэтгэлзүй, олон нийтийн санаа бодлыг эзэмдэж байна.**



Хэдийгээр энд засаглалын хэлбэрийн асуудлыг уран илтгэхүйн үр нөлөөтэй холбон тайлбарлаж буй боловч цаад утгаараа ямар харилцаа байна тийм нийгмийн дэг журам, ёс суртахууны үнэлэмж тогтдог болохыг өгүүлж буй хэрэг. Өөрөөр хэлбэл мэдээлэл харилцааны орон зай өөрийн оршин байгаа тогтолцоогоо хамгаалах зорилго дор бүрэлддэг гэсэн үг. Тиймээс манайд баян хоосны ялгаа, ядуурал, үнийн өсөлт, авлига, уул уурхай зэрэг эд баялгийн “шунал” тойрсон эрс үгүйсгэл, туйлшрал нийгмийн сэтгэлзүй, олон нийтийн санаа бодлыг эзэмдэж байна. Гэхдээ хамгийн гол нь хөрөнгө бүхий хэсгээ үзэн ядах, технологи, шинжлэх ухааныг үгүйсгэх, халамж тэтгэлгийг хэт шүтэх үзэл нийгмийн суртахуун бүхнийг эрхшээж, хүний эрхэм чанар, амьдрал хувь заяаныхаа эзэн байх эр зориг, бахархлыг үгүйсгэж ирсэн нь бидний эмгэнэл юм. Харилцаа, мэдээлэл гэдэг үл үзэгдэх, нууцлаг хүч нийгмийн бүхий л салаа, хүрээг өөрийнхөө хяналт, нөлөөнд оруулдаг бодит үнэн нь өнөөгийн Монголын нийгмийг үнэлэх, ойлгох чухал нэгэн өнцөг, байр суурь гэдгийг дахин тэмдэглэж байна. Үнэхээр ч бид юу болохгүй байгаа, хэрхэн засах тухай олныг өргөн хүрээнд ярьж хэлэлцдэг хэр нь шийдвэр, үйлдэл хийж чадахгүй байгаа нь ч харилцааны орчин ба мэдээллийн орон зай хоорондын үл нийцэл, зөрчлөөс улбаатай шалтгаанд оршиж байна.

Их сэтгэгчийн бүтээлийн өөр нэгэн өнөөгийн Монголын нийгмийн

харилцаанд чухал санаа нь “... хэрэв чи магтахыг хүсэж байгаа бол анхаарагтун, чи зөвлөгөө өгөх ёстой, харин чи зөвлөгөө өгөхийг хүсэж буй бол анхаарагтун, чи магтах ёстой” (Аристотель, 2009)<sup>10</sup> гэсэн дүгнэлтэд байна. Монголчуудын эртнээс нааш оршиж ирсэн төрт ёсны соёл, уламжлалд хурилдай, чуулган нь өрнөдийнх шиг ямар нэгэн сорилт, бэрхшээл, маргааныг шийдвэрлэхэд бус харин хаан, эзэндээ зөвлөх, саналаа илэрхийлэхэд төвлөрч байв. Энэхүү үндэстний соёлын мөн чанар өдгөө ч гэсэн үргэлжилсээр авай. Гэвч бид аливаа үйл, үзэгдлийг хэлэлцэхэд нэгдүгээрт туйлын төгс шийдэл, зөвлөгөөг олох гэж мухарддаг (үнэндээ тийм ухаан хэнд ч үгүй) хоёрдугаарт зөвлөгөө өгөхдөө хэн нэгэн эсвэл ямар нэгэн хууль дүрмийг хэт үгүйсгэдэг, гуравдугаарт хэнд эсхүл ямар байгууллага эрх мэдэн шийдэх нь тодорхойгүй зөвлөдөгт үр дүнгүй үг яриа, хурал, уулзалтын жинхэнэ шалтгаан буглаж байна.

**Б**үтээлийн 12-р бүлэгт “Хүмүүс, тухайн авир үйлдлээ гаргахад хэнээс ч үл хамаарах боломжтой, өөрийнх нь хувьд ч бололцоотой гэж үзсэн үедээ шударга бусаар авирладаг байна; түүнээс гадна тэдний эл авир үйлдэл илрэхгүй” хоцорно гэх юм уу эсхүл илэрсэн тохиолдолд ч үүнийхээ төлөө цээрлэл амсахгүй гэж ... цээрлэл хүлээлээ ч энэ шийтгэл нь ... өөрснөө юм уу эсхүл ойр дотных нь хүмүүс олох ашгаас үлэмж бага байх болно гэж бодсон үедээ шударга бусаар авирладаг” (Аристо-

тель, 2009)<sup>11</sup> гэж тов тодорхой манай мэдээллийн үр нөлөөний хямрал, хязгаарлагдмал байдлын мөн чанарыг тайлбарлажээ.

**М**онголчууд бид шударга ёс, тэгш эрх, авлига үгүй төрийн тухай олон дахин, хангалттай ярьж, нэг талаас эрх мэдэлд хүрэх үзэл санааны (Ц.Элбэгдорж 2009, 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа, 2008-2020 оны УИХ-ын сонгуулийн гуравдах хүчний үзэл баримтлал гэх мэт) нөгөө талаас нийгмийн үнэлэмж, үндэсний эрхэм зүйл, улс орны тэмүүлэл болгон (Үндсэн хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг зэрэг) төлөвшүүлэх гэж их хүч, чармайлт гаргасан боловч үр дүн дулимаг хэвээр байна. Үүний шалтгаан нь ч дээр өгүүлсэн гэм зэмийг үл тоомсорлох, жудаг үгүй хувь хүний аминч үзэл бүхнийг эрхшээж буй мэт нийтийн төөрөгдөл (стереотип) манай мэдээллийн орон зайд ноёрхож байгаатай холбоотой. Үнэхээр ч тэрбум төгрөгөөр багцаалагдах авлига, хулгай, дээрмийн гэмт үйлдлүүд тухайн үедээ дуулиан шуугиан болоод мартагдаж, гэмтнүүд хөрөнгө мөнгөтэй үлдэж бүр цаг үеийнхээ баатар болсон жишээ бидний мэдээллийн орон зайн түүхнээ олноор бичигджээ. Хамгийн эхний томоохон луйвар болох Гансүхийн 90 сая төгрөгийн хэрэг (1996 онд энэ мөнгө өнөөгийн тэрбум төгрөгтэй дүйцнэ) өдгөө агуу ухаант, бахархалт хүний тухай кино болж, хувьчлал, улс өмчийн шамшигдуулалтын луйвар нь ардчилсан хувьсгалын санхүүжүүлэгч бүлэглэ-

лийн алсын бодлого байсан мэтээр (“37-р точка” олон ангит кино) олон нийтийн санаа бодолд төлөвшиж байна. Ийм жишээ Оюу толгой, Таван толгой, Эрдэнэт зэрэг томоохон уул уурхайн компани тойрсон мэдээллийн их түрэлтээс үе үеийн төр засгийн хэрэгжүүлсэн төсөл, зээл, тендер, халамжийн хөтөлбөр хүртэл үргэлжилнэ.

Өөрөөр хэлбэр 1990 оноос хойших улс төр, эдийн засгийн мэдээллийн орон зайн бий болгосон олон нийтийн санаа бодол нь “мөнгөтэй нь хөгжмөө захиалдаг” гэсэн төөрөгдлийг нийгмийн бүх хүрээнд бүр хувь хүний итгэл үнэмшлийн цогцод төлөвшүүлжээ. Тиймээс дуулиан шуугианд нийгмээрээ ховсдуулж, луйвар, хулгай, жудаггүй бүхнийг байх ёстой, байсаар ч байна” гэсэн бурангуй түвшинд өргөмжилжээ. Хамгийн эмгэнэлтэй нь бид материаллаг баялгийг нийгмийн орь хүсэл хэмээн итгэж, түүгээрээ ёс суртахуун, оюун санааныхаа нандин бүхнийг үнэлэх болсон. Энэ бол мэдээллийн орон зайн эрх мэдэл, засаглалын хүсээгүй үр нөлөөний бодит үр дагавар мөн. Гэтэл шударга ёс гэдэг алдах юмтай хүний эр зориг бас хариуцлага нь байдаг. Эртний Грект “өөрийн өмч болох газартай, дайнд оролцох чадвартай, зэр зэвсэг, унаа морио гаргадаг” зэрэг алдах юмтай хүн өөр улсад дайн зарлах эсвэл бууж өгөх эсэхийг шийдэх сонгуулийн эрхтэй байсан. Тиймээс ч шударга, эрх чөлөөт, бүрэн эрхт иргэн байсан. Харин бид алдах юмгүй, үймсэн олон нийтийн сонгол-

тоор улс төр, эдийн засаг, нийгмийн онцгой чухал шийдвэрийг гаргаж байна. Сэтгүүл зүй шударга ёсыг тогтооход үүрэг, нөлөөтэй гэдэг нь ч элитийн хараат бус, бодит, зүй ёсны эрх мэдлийг хадгалахад оршино.

Аристотелийн агуу бүтээлийн хоёрдугаар дэвтэр нь сэтгүүл зүй олон нийтийн харилцааны өнөөгийн асуудлыг үнэлж цэгнэхэд үлэмж чухал санааг дэвшүүлжээ. Түүнээ “ярьж буй хүнд итгэх итгэлийг үүсгэдэг гурван шалтгаан бий,... энэ нь оюун ухаан, сайн үйл, талархалт хандахуй гурав юм” (Аристотель, 2009)<sup>12</sup> хэмээн уран илтгэхүйн итгэл үнэмшил, нөлөөллийн мөн чанарыг тодорхойлжээ.

**Ү**нэхээр дээрх нөлөөллийн хүчин зүйлс нь өнөөгийн нийгмийн харилцааны суурь онол, үзэл баримтлалын “ухаан” бөгөөд дэлгэрүүлбэл, үзэл санааны лидер байх (оюун ухаан), шинэ үзэгдэл, амьдралын хэв маяг сорилт, бэрхшээл зэрэг бодит үйл явдалд суурилах (сайн үйл), удирдагч манлайлагчийн увдис, эр зоригтой байх (талархалт хандахуй) гэсэн гурвалсан нөлөө итгэл үнэмшлийн цогцыг онцолдог. Харин манай нийгмийн харилцаанд (PR) олон нийтийн санаа бодлыг аялдан дагах (үзэл санаа үгүй), амлалт, хэт туйлшрал, ирээдүйн айлдварт автах (бодит үйл хэрэгтэй холбоогүй), томоохон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт үгүй (сайн үйл үгүй) зэрэг нөлөө, итгэл үнэмшлийн ямар ч хүчин зүйлд нэгтгэгдэхгүй мэдээллийн орон зай ноёрхож байна.

Түүнчлэн уур хилэнгийн тухай

“боллоцгоогүй хэмээн санагдсан тэр зүйл рүүгээ хэн ч эрмэлздэггүй, иймд хилэгнэж буй хүн боллоцгоотой гэж бодсон тэр зүйл рүүгээ эрмэлздэг” (Аристотель, 2009)<sup>13</sup> байна гээд оюун ухааны үгүйсгэл нь үл тоох, сэтгэлзүйнх сэхүүн ааш, үнэт зүйлийнх доромжлох гэжээ. Монголын нийгмийн харилцааны өнөөгийн орон зайд ч үл тоох (шинэ санаа үзэл баримтлалыг үгүйсгэх, олон нийт үл ойлгох, үл хүлцэн тэвчих), сэхүүн аашлах (нийгмийн эрх ашгийг үл хэрэгсэн, аминч үзэл бүхнээс илүү хэмээн үзэж, “Би” төвт үзлээр бүхнийг хэмжих), доромжлох (бусдыг үгүйсгэх гутаан үгүйсгэх, ялгаварлан гадуурхах байдлаар сэтгэлийн ханамж авах) гэсэн мэдээллийн довтолгоо, итгэл үнэмшил, нөлөөллийн орон зай нийгмийн сүлжээнээс, сэтгүүл зүйн хүрээ хүртэл бодитоор оршиж байна. Ийнхүү манай нийгмийн элит, лидер нь хүндэтгэл үгүй, бөгөөд олон нийт нь ч дээдлэх үнэт зүйл эрхэмлэлгүй хилэгнэл, туйлшралын дуулианд автаж байна. Ийм агуулга бүхий “Монгол коммент” (ТВ9) гэсэн мэргэжлийн ёс зүйн гажуудал болсон нэвтрүүлгээс бараг бүх мэдээллийн хөтөлбөр (MYONTV, Eagle, Mongol HD, Bloomberg-ээс бусад) сайтуудын мэдээний агуулгад ноёрхож, улмаар олон нийтийн санаа бодолд нөлөөлж байна.

Энэхүү нөлөө хүн хоорондын харилцаа, аман мэдээллийн орон зайд мэдээлэгчийн үзэл бодол, төөрөгдлөөр (стереотип) илүү туйлшрал, үгүйсгэлийн худал гажуудлын утга агуулгаар нэмэгдэж, тэр хүрээ чанараараа нийгмийн



сэтгэлзүйг бухимдал, хямралаар нэрвэж байна. Тэгээд ч Аристотелийн “Илтгэгчийн үүрэг бол сонсогчдыг хүмүүс уурладаг тийм төлөв байдалд оруулаад эсрэг тал бол (сонсогчид) уурлах ёстой тэр зүйлд холбогдолтой гэдгийг нь бас (эсрэг талынхан) хүмүүсийн уурыг хүргэдэг тэр л зүйлийг хийж явдаг гэдгийг (сонсогчдодоо үнэмшүүлэхэд) оршино” (Аристотель, 2009)<sup>14</sup> хэмээн дүгнэсэн нь өнөөгийн бидний санаа бодол, төсөөлөл (төөрөгдөл) итгэл үнэмшлийн бурангуй, эрүүл бус “чанар”-ын шалтгаан билээ. Энэхүү сэтгэлзүйн гутрал цар тахлын (Ковид-19) үеийн төрийн мэдээллийн зорилго болоод үр нөлөөний цөм, “түлхүүр утга чанар” нь байсан гэдэг нь ч халдвар тархаагүй үед улс орноор нь хөл хорио тогтоож, айдас түгшүүрээр бүхнийг эрхшээж, засаглаж байсан гашуун үнэн батална.

**Е**р нь Монголын нийгмийг айдас, дайсагнал, ялгаварлан гадуурхалтаар “удирдаж” эрх мэдэл, нөлөөгөө тогтоож байгаа жишээ өнөөдрийг хүртэлх бүх УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн PR, ухуулга сурталчилгаанаас төсөв, халамжийн бодлого, нийгэм эдийн засгийн төсөл хөтөлбөрийн мэдээллийн орон зайн түрэлт гээд бүгдэд бийг тоочиж, нэрлэхэд урт жагсаалт гарна.

Ийм мэдээллийн орон зай, нийгмийн сэтгэлзүй хэнд (ямар илтгэгч, мэдээлэгчид) хэрэгтэйг ч Аристотель “... уур хилэн агаад дайсагналын нөлөөгөөр эргэлзээнд орсон хүмүүсийг аль ч хамаагүй тал уруугаа хэлбийлгэх бололцоотой

зэрэг нь илэрхий байна” (Аристотель, 2009)<sup>15</sup> гэж тов тодорхой дүгнэжээ. Үнэхээр ч Монголын олон нийтийн хэт үгүйсгэл, туйлшрал (бурханлаг, төгс, аврагчийг эрэлхийлдэг, өдгөө буй бүхнээ үзэн яддаг), өөрөөсөө бусдыг үгүйсгэдэг, аливаа сорилт бэрхшээлийн шалтгааныг гаднаас, хэн нэгнээс хайдаг, бүр түүндээ итгэн үнэмшдэг (Хятадын аюул, оросын хүйтэн сэтгэл Монголыг сүйдэлж байна мэтийн) дайсагнал, айдас, үзэн ядалтын сэтгэлзүйн гүн хямралд автагдсан (хөрш орнууд болоод бусдын өшөө авалт нийгэм эдийн засгийн хямралын гол шалтгаан болж байна, гадаадын хөрөнгө оруулалт бол мөлжлөг мөн, хөрөнгө мөнгөтэй бүхэн луйварчин, жирийн хүний дайсан зэрэг төөрөгдөл) гээд бидний бодит, гунигт, эмгэнэлт байдлын шалтгаан нь Аристотелийн бичсэнээр “... үзэн ядахуй бол үл эмчлэгдмү ... үзэн ядахуй бол муу муухайг учруулах гэсэн эрмэлзлэл” (Аристотель, 2009)<sup>16</sup> хэмээсэнд оршиж байна. Харин эерэг зүйл бол түүнийхээр өөртөө хүсдэг зүйлээ өөр нэгэнд хүсэж буй бол найз, ... бидний дайсанд дайсагнан хандаж байгаа бол ... найзын шинж (халамж, төрийн хэт оролцоо, технологийн шок, өнгөрсөн үеэрээ бахархах эдгээр үзэл бол бидний дайсан, ДОХ) зэргээр тоочжээ.

Товчоор хэлбэл хүн байх, хүн шиг амьдарч хөдөлмөрлөх, хүний эдлэх баяр жаргал, буяныг хүртэх эрхийг хэн дээдэлж, хүлээн зөвшөөрч тийм боломжийг олгоно тэр

бүхэн найз, анд харин үгүй нь бидний дайсан, айдас болно.

Ийм үзэл шүүлтүүрээр Монголын нийгмийн сэтгэлзүй, мэдээллийн орон зайг тодорхойлбол, их сэтгэгчийнхээр “илтгэгч цаад хүмүүсээ хэнийг ч зовлон шаналалд оруулж чадах этгээд (гэж харуулах хэрэгтэй) (үүний тулд илтгэгч сонсогчдынхоо анхаарлыг) тэднээс илүү хүчирхэг хүмүүс хэрхэн хэлмэгдсэн, “зовлон шаналалд унагаана гэж бодоогүй тийм хүмүүсийн талаас ... ийм тийм юман дээр, тийм-тийм тохиолдолд муу зүйлд өртөж болно, өртсөн явдал бий гэдэг рүү хандуулах хэрэгтэй” (Аристотель, 2009)<sup>17</sup> гэсэн загварт бүрнээ нийцэж байна. Мэдээж дээр өгүүлснээр Аристотелийн ичгүүр (ёс суртахууны муу чанараас гарч буй үйлдлүүд, бусдын зүгээс доромжлох, нэр хүндийг сэвтээх, бялдуучлах, зусардах) хэт мөрөөдөх, хүсэх (зовж шаналахдаа хүсэл мөрөөдөлд хэт автдаг) өрөвдөхүй (аюул, мөхөл, зовлон өрөвдө-

хүйг үүсгэдэг) гэсэн үзэл онол, тайлбарыг өнөөгийн Монголын нийтлэл, нэвтрүүлгийн үр нөлөөний шалтгаан, үндэслэл болгон тайлбарлаж болно. Гэхдээ дүгнэлт нь эсрэгээр, итгэн үнэмшүүлэл бус гутранги үзэл хэт догдлолд автсан гэсэн онош ноёрхож байгаа нь эмгэнэлтэй. Учир нь илтгэхүй бол үнэнийг нээх зорилготой мэтгэлцэх ур чадвар, эхлэлийг олох үнэцэнтэй (мөн чанар, эрүүл оюун дүгнэлт), ёс суртахуун, гоозүйн дээд баримтлалын үүрэг нөлөөгөөр сая хүний болоод нийгмийн зайлшгүй харилцаа болдог зүйл юм.

Бидний цаг үед зэвүүрхэл хэмээх нийгэм, эдийн засгийн элит, оройлогч хэсгээ үзэн ядах сэтгэлзүй яагаад хүчтэй болсныг асуувал сэтгэгч маань “...өөрсдөөс нь болоогүй гай зовлонд холбогдсон сэтгэл өвдөхүйн мэдрэмж ... зүй бусын цэнгэл жаргалыг харснаас гарах сэтгэл өвдөхүйн мэдрэмж” (Аристотель, 2009)<sup>18</sup> хэмээн хариулжээ.

«

**Мэдээллийн сайт кино, энтертайнмент хөтөлбөр, нийгмийн сүлжээний мэдэгдэл (post) гээд өнөөгийн хүний хамгийн их сонирхол, анхаарал татдаг бүтээгдэхүүний дүр илэрхийлэл, агуулгад (контент) хөрөнгөлөг болоод эрх мэдэл бүхий хүрээнийхэн хэт тансаглал, өрнөдшилт, материаллаг баялгийн давуу талыг илэрхийлэгч, бүр эрхэмлэгчид болсон нь нэг талаас баян ядуугийн хэт ялгарал, эдийн засаг санхүүгийн тэгш бус байдал, улс орон, үндэсний хямрал зөрчлийн гол буруутан нөгөө талаас энэ бүх шударга бус замаар олсон хөрөнгөө хэт чамирхал, хэрэглээнд үр ашиггүй зарцуулж буй мэтээр төсөөлөгдөх болсны шалтгаан**

**юм.**

»

мэдрэмж ... зүй бусын цэнгэл жаргалыг харснаас гарах сэтгэл өвдөхүйн мэдрэмж” (Аристотель, 2009)<sup>18</sup> хэмээн хариулжээ.

Мэдээллийн сайт кино, энтертайнмент хөтөлбөр, нийгмийн сүлжээ-ний мэдэгдэл (post) гээд өнөөгийн хүний хамгийн их сонирхол, анхаарал татдаг бүтээгдэхүүний дүр илэрхийлэл, агуулгад (контент) хөрөнгөлөг болоод эрх мэдэл бүхий хүрээнийхэн хэт тансаглал, өрнөдшилт, материаллаг баялгийн давуу талыг илэрхийлэгч, бүр эрхэмлэгчид болсон нь нэг талаас баян ядуугийн хэт ялгарал, эдийн засаг санхүүгийн тэгш бус байдал, улс орон, үндэсний хямрал зөрчлийн гол буруутан нөгөө талаас энэ бүх шударга бус замаар олсон хөрөнгөө хэт чамирхал, хэрэглээнд үр ашиггүй зарцуулж буй мэтээр төсөөлөгдөх болсны шалтгаан юм. Үнэхээр ч мэдээллийн орон зайд манай элит хүрээнийхэн илүү энгийн, ухаалаг, нийгмийн хариуцлагаа дээдлэгч дүр, сэтгэхүйг бүтээх нь өөрсдөд нь ч, олон нийтэд ч эерэг таатай, зөвшилцлийн харилцааны орчныг төлөвшүүлэх үр нөлөөтэй хүчин зүйл билээ.

Аристотелийн бидэнд тун чухал, үнэ цэнтэй сургаал нь үг ярианд жишээ баримт ашиглах тухай зөвлөмж юм. Түүнээ “нотолгоо хэлэх үед энтимем (товчилсон логик дүгнэлт) олдохгүй байгаа тохиолдолд жишээг ашиглах хэрэгтэй, ятгаж үнэмшүүлэхэд ямар нэгэн нотолгоо заавал хэрэгтэй; харин (энтимемүүд) олдчихсон байгаа бол жишээнүүдийг оршил үг маягтайгаар энтимемийн хойно нь байрлуулж гэрчлэл мэтээр ашиглах хэрэгтэй. Хэрэв жишээг эхэнд нь хэлчих юм бол энэ нь хөтлөл лүгээ адил

болчихно гэтэл хөтлөл (индукц) болбоос яруу илтгэхүйд цөөн тохиолоос бусад үед сайн тохирдоггүй... жишээг үгийн төгсгөлд гаргаж хэлбээс тэр нь гэрчлэл болно, гэрчлэгч ямагт итгэл төрүүлнэ” (Аристотель, 2009)<sup>19</sup> гэжээ.

**Э**нэхүү дүгнэлт сэтгүүл зүйн мөн чанар болох баримтыг (жишээ) хэрхэн үнэ цэнтэй, учир шалтгаантай болгон ашиглахын үндэс нь “баримт бол цаад үзэл санаа мөн, харин үзэл санаа нь илт баримтыг тээгч юм” гэсэн гүн ухаанд оршиж байна. Өөрөөр хэлбэл, цаг үеийн үйл явдал, баримтыг нийгэмд хүргэх нь зүгээр нэг мэдээллийн дамжуулал бус харин энтимем (олон нийтийн санаа бодол, нийгмийн үнэлэмж зэрэг) бүхий эсвэл тийм утга тайлбартай холбох цаашилбал итгэн үнэмшүүлэх зорилгод үйлчлэх ёстой гэсэн үг.

Өөр нэгэн уран илтгэхүйн “багаж, хэрэгсэл” нь эш үг бөгөөд “салангид жижиг тохиолдолд бус ... харин нийтлэг учир холбогдолтой зүйлд хамаарсан баталгаа үг юм” (Аристотель, 2009)<sup>20</sup> гээд “хэрэв энтимемийн дүгнэлт, гаргалгаанаас силлогизмын хэлбэрийг хасчих юм бол энтимем нь эш үг болчихно” (Аристотель, 2009)<sup>21</sup> гэжээ.

Монголын сэтгүүл зүй өдгөө ч аман харилцаа ноёрхон төлөвшсөн нүүдлийн соёлын онцлог, мөн чанартай холбоотойгоор эш үгийн (зүйр цэцэн үг, сургаал, хошигнол, оньсого, ертөнцийн гурав, хүнчлэл, амьдчилал) хэрэглээ, нөлөөг ур чадварын шалгуур хэмээн үзсээр байна. Нөгөө талаар эш үг нь “амьдралын

асуудлыг тойрсон ... үйл амьдралд юуг нь сонгож, юунаас зайлсхийх ёстойд холбогдон” (Аристотель, 2009)<sup>22</sup> “шалтгаан тайлбарыг нэмэн энтимем” болох утга агуулга нь тэлэн өргөждөг онцлогтой ажгуу. Ер нь монголчууд үр хүүхдээ эш үгээр хүмүүжүүлж, өөр хоорондоо үзэл бодлоо илэрхийлэхдээ зүйр цэцэн үгээр тодотгож, аливааг үнэлж дүгнэхдээ сургаал, хэлц үгээр дамжуулж ирсэн уламжлалтай үндэстэн учир хүн, нийгмийн харилцааны үргэлжлэл болох сэтгүүл зүйн ур чадварын үнэлэмж, шалгуурт оршоор байх нь ойлгомжтой.

**И**х сэтгэгчийн “яруу гоё агаад оносон сайн илэрхийллийг олж зохиох нь авьяастай төрсөн юм уу туршлага суусан хүний чадвар юм, харин (эдгээрийн онцлог нь юунд орших вэ гэдгийг) нээн харуулах нь уран илтгэхүйн ухааны хэрэг юм” (Аристотель, 2009)<sup>23</sup> гэсэн нь сэтгүүл зүйн онолын тодорхойлолтод шууд дүйж байна. Үнэхээр ч сэтгүүлчийн ур чадвар бол төрөлх авьяас эсвэл олон арван жилийн хөдөлмөр туршлагаас үүддэг ухаан сэтгэлийн нэгдэл бөгөөд түүнийг үнэлж ойлгох нь сэтгүүл зүйн онол, үзэл баримтлалын зорилго билээ. Цаашилбал ямар маягийн үг яриа, тайлбар үр нөлөөтэй вэ гэдгийг “ийнхүү зүйрлэл, сөргүүлэн тавихуй, нүдэнд тустал харуулахуй гэсэн энэ гурван зүйл рүү эрмэлзэх хэрэгтэй” (Аристотель, 2009)<sup>24</sup> гэж хариулжээ. Үүнийг өнөөгийн сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийн ангилалтай дүйцүүлэн үзвэл зүйрлэл нь уран сайхны, сөргүүлэн тавихуй нь

анализ дүн шинжилгээний харуулахуй нь мэдээллийн хэмээн бууж байна.

Ийнхүү эцэст нь нэгтгэн дүгнэвэл аман харилцаа ноёрхож байсан үед өрнөдийн тэргүүлэгч сэтгэгчийн дэвшүүлсэн үзэл санаа нь өнөөгийн мэдээллийн үр нөлөө, сэтгүүлчийн ур чадвар, сэтгүүл зүйн хөгжил өөрчлөлтийг (нэн ялангуяа Монголын) үнэлж тодорхойлоход үнэт ухаан болно. Нөгөө талаар мэдээллийн технологи, хэрэгслийн эрхшээл нөлөө бүхий өнөө үед ч хүний харилцааны уг суурь, цөм болсон аман мэдээллийн мөн чанар хэвээр бүр бүхний (нийгмийн харилцааны бүх хэлбэр) эхлэл хэвээр гэдэг утгаараа судлан эргэж харууштай бүтээл мөн. Хамгийн сонирхолтой нь нийгмийн сүлжээ хэмээх даяар мэдээллийн аман харилцааны бүрэн нөлөөллийн энэ цаг үед Аристотелийн итгэн үнэмшүүлэх зорилгот, ухаалаг мэтгэлцээний үнэ цэнэ, ач холбогдол улам бүр өссөөр байна.

#### Эшлэл

1. Юнг. С. 2006 Социальная история ПР. М. 18 с.
2. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 6.тал
3. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 29.тал
4. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 30.тал
5. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 32.тал
6. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 39.тал
7. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 43.тал
8. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 44.тал
9. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 48. тал

10. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ.50. тал
11. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 66. тал
12. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. тал.88
13. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. тал.89
14. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 94. тал
15. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 101.тал
16. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 102. тал
17. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 104.тал
18. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 115.тал
19. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 136. тал
20. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 136.тал
21. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 137. тал
22. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 137. тал

23. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 188. тал
24. Аристотель 2009. Уран илтгэхүйн ухаан УБ. 189. Тал

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Аристотель. 2009. Уран илтгэхүйн ухаан. УБ.
2. Аристотель. 2006. Улс төр. УБ.
3. Аристотель 1978. Сочинения в четырех томах Т.2. М.
4. Юнг. С. 2006 Социальная история ПР. М.

#### **Summary**

This paper explains the Mongolian mass communication environment based on ancient Greek philosopher Aristotle's view in his book "Rhetoric". It highlights how Mongolian government and its' PR, and the mass media shaped public opinion during the pandemic.